

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн, Батмөнх Энхжаргал

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца		
			1	2	3	4	5	6
1.1. Худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;								
1	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, хувиар	Хоёр талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх хүрээнд нийт 5 санамж бичиг, 2 протокол байгуулсан Нийт 22 хэлэлцээрийн төсөл, 26 ярианы сэдэвт санал боловсруулж, холбогдох чиг үүргийн яамдад хүргүүлсэн.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төслийг айлын талтай эцэслэн тохиролцох үүрэгтэй Ажлын хэсэг, Дэд ажлын хэсгийг Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 2024 оны 44 дүгээр тэмдэглэлийг үндэслэн Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/02 дугаар тушаалаар шинэчлэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%	

					байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 01/269 тоот албан бичгээр Дэд ажлын хэсгийн санал болох хэлэлцээрийн төслийн Монгол Улсын тарифын амлалтын жагсаалтаас БТКУС-ын 6 оронгийн түвшинд 23 нэр төрлийн барааг хасуулах тухай хүсэлт ирүүлж, улмаар айлын талтай барааны жагсаалт тохиорх хэлэлцээг үргэлжлүүлж, талууд албан шугамаар харилцан гурван удаа санал солилцсон. ОХУ-ын Москва хотноо 2025 оны 3 дугаар сард зохион байгуулсан албан ёсны хэлэлцээний явцад монголын тал хүнсний салбарын бараа, бүтээгдэхүүнийг хэлэлцээрийн хүрээнд бүрэн татвараас чөлөөлөхгүй байх, дотоодын зах зээлийг хамгаалахад онцгойлон анхаарсан бөгөөд хэлэлцээний үр дүнд Монголын талаас хасуулахаар санал хүргүүлсэн 23 бараанаас 8 барааг бүрэн хасуулж, 11 бараанд айлын тал буулт хийн татварыг	
--	--	--	--	--	---	--

				<p>бууруулах эсхүл квот тогтоохоор тохиролцож, 4 барааг жагсаалтад хэвээр үлдээсэн. Худалдааны түр хэлэлцээрийн төслийг 2025 оны 4 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Монгол Улсын Их Хурлын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодоор хэлэлцүүлсэн бөгөөд Олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас холбогдох байнгын хороодтой зөвшилцсөний үндсэн дээр тус олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад олгосон бөгөөд хэлэлцээрт 2025 оны 6 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p>	
1.2. Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх,					

Хэрэгжилтэд хяналт тавих;							
2	Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн ба Ази номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр, Европын холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд тус тус нэгдэн орсон байх ба Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан.	Тухай бүр судалгаа хийн дүгнэлт гаргаж, санал боловсруулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Монгол Улс, Япон Улс хооронд 2016 онд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь монголын анхны бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ганц чөлөөт худалдааны хэлэлцээр бөгөөд тус хэлэлцээрийн үр дүн, хэлэлцээрээр тохиролцсон зохицуулалтын нөлөөлөл, үр ашиг, сул талыг судлан шинжилж, одоогийн хэлцэл хийж буй шинэ худалдааны хэлэлцээрүүдийн хэлэлцээний ажилд ашиглан, нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан. Монгол Улс, Япон Улс хооронд 2016 онд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр дүнг сайжруулах зорилго бүхий судалгааг хийхээр ажлын даалгавар боловсруулах ажил эхэлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж,	Хэрэгжилтийн явц, хувиар	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох,	Тухай бүр судалгаа хийж, санал	Гадаад худалдааны тэнцлийг сайжруулах, уул уурхайн бус	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар	100%

<p>хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханганд, хэрэгжилтэд хяналт тавина.</p>	<p>худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханганд ажилласан. Худалдааг хөнгөвчлөх, уул урхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж батлуулсан.</p>	<p>боловсруулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/</p>	<p>бүтээгдэхүүнийн экспортын боломж, гадаад зэх зээлийг тэлэх зорилгоор эдгээр бараануудад татварын нэн таатай нөхцлөөр экспортлох боломж бүрдүүлэхээр БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хүрээнд 4 шатны албан ёсны яриа хэлэлцээг хийгээд байна. Мөн Монголын хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг татваргүйгээр ОХУ-ын зах зээлд гаргах зорилгоор ЕЭАЗХ-той Худалдааны түр хэлэлцээр байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон. Тус хэлэлцээрийн үр дунд монголын экспортлох боломж бүхий харьцангуй давуу талтай хөдөө аж ахуйн гаралтай голлох бараанууд бүгд татваргүйгээр экспортлогдох боломжтой бөгөөд махны квотын хязгаарлалтгүйгээр экспортлох ач холбогдолтой. Худалдааг хөнгөвчлөх бодлогын хүрээнд гадаад худалдааны үйл</p>	<p>5-р 6-р 7-р 8-р 9-р 10-р 11-р 12-р cap</p>
--	---	--	---	---

ажиллагааг бүрэн цахимжуулж, оролцогч байгууллагууд болон гадаад худалдаа эрхлэгчдэд тулгарч буй хүндэрлүүдийг бууруулах хүрээнд Гадаад худалдааны цахим нэг цонх мэдээллийн систем нэвтрүүлэх ажлыг албан ёсоор эхлүүлээд байна. Тус мэдээллийн системийн "Ажлын даалгавар"-ыг шинэчилсэн бөгөөд АХБ-тай хамтран 3 сарын 21-23-ны өдрүүдэд тус системийн талаарх техникийн сургалт, хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудын төлөөллийг хамруулан зохион байгуулсан. Мөн системийг нэвтрүүлэх, ашиглахтай холбогдуулан хууль эрх зүйн орчны судалгаа, дүн шинжилгээг хийсэн бөгөөд ЦХИХХЯамнаас ГХЦНЦ системийн дүгнэлт, зөвлөмж хүлээн авч, ажлын даалгаварыг баталсан. Тус системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх олон улсын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газар тендерийн үнэлгээний

					хороо тендерийн бичгүүдийг байгуулж, баримт эцэслэн боловсруулсан.		
4	Нэгжийн худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавина.	Хэрэгжилтийн явц, хувиар	Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны үйл ажиллагааг холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг баталсан. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн Б/22 тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн зүгээс холбогдох удирдамжийн дагуу холбогдох хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулж ажилласан.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны үйл ажиллагааг холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг, удирдамжийг баталсан. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024 оны Б/22 тушаалаар батлагдсан бүрэлдэхүүн холбогдох удирдамжийн дагуу холбогдох хяналт, шалгалтыг зохион байгуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх	-	Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна	1. Монгол, Тайландын хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр (2024-2025)-ийн хүрээнд Тайландын Хаант Улсын Бангкок хотноо зохион байгуулсан "Нэг тамбон (хороо) нэг бүтээгдэхүүн" орон нутгийн бараа бүтээгдэхүүн хөгжүүлэх сургалтад хамрагдсан. 2. Дэлхийн банкны санхүүжилттэй Цахим, хөгжил, харилцаа холбооны яамны хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг-2" төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд багтсан бараа болон мэдээллийн систем худалдан авах Дэлхийн банкны журмын талаар танилцуулсан сургалтад 2025 оны 04 сарын 18-нд хамрагдсан. Санхүүжилтийн гэрээнд заасны дагуу худалдан авалт, тендерүүдийг Дэлхийн банкны худалдан авалтын журмаар явуулах учраас томоохон үнийн дүнтэй тендерүүдийн үнэлгээг хийхээс өмнө үнэлгээний хорооны гишүүдэд мэдээлэл өгөх зорилготой сургалт юм.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх	-	Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна.	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт идэвхитэй хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	100%

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ТЗҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Баясгалан /.....

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн, Батмөнх Энхжаргал /...../

Огноо: 2025.06.25

